



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2015 оны 12 сарын 01 өдөр

Дугаар А/545

Хэрлэн сум

Мал тооллогын комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.1-ийн "г", 30 дугаар зүйлийн 30.1.15, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.17, Статистикийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2012 оны 239 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журмын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. 2015 оны жилийн эцсийн мал тооллогын ажлыг зохион байгуулах аймгийн комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

- | | |
|-----------------------|---|
| Комиссын дарга: | -Аймгийн Засаг даргын орлогч |
| Орлогч дарга: | -Аймгийн Статистикийн хэлтсийн дарга |
| Нарийн бичгийн дарга: | -Статистикийн хэлтсийн ХАА хариуцсан мэргэжилтэн |
| Гишүүдэд: | -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга |
| | -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга |
| | -Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга |
| | -Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны дарга |
| | -Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга |
| | -Онцгой байдлын газрын дарга |
| | -Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга |
| | -Татварын хэлтсийн дарга |
| | -Ус цаг уур орчны шинжилгээний төвийн дарга |
| | -Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын |

022584

Захирагч

Хоёр. Жилийн эцсийн мал тооллогод зарцуулах хөрөнгийг хавсралтаар баталсугай.

Гурав. Багт ажиллах тоочдыг семинар гарын авлагаар хангаж, хугацаанд нь гаргах, оторт яваа малчдыг тухай орон нутгийнх нь удирдлагатай холбогдож тооллогод бүрэн хамруулах, гүйцэтгэлийн хяналтыг сайн зохион байгуулахыг сумдын Засаг дарга, хот, тосгоны Захирагч нартдаалгасугай.

Дөрөв. Мал тооллогод зарцуулах 3600000/ гурван сая зургаан зуун мянган/ төгрөгийг аймгийн нөөц сангийн мал тооллогын зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Хэрлэнчимэг/-д зөвшөөрсүгэй.

Тав. Жилийн эцсийн мал тооллогын ажилд комиссын гишүүдийг ажил хэрэгчээр оролцуулж, сумдын тооллогын явцад анхаарч хяналт тавьж ажиллахыг комиссын даргад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.ОЮУНБААТАР



Аймгийн Засаг даргын 2015 оны
12 дугаар сарын 01 өдрийн А/346
дугаар захирамжийн хавсралт

2015 ОНЫ МАЛ ТООЛЛОГОНД
ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Сумдын нэр	Олгох зардал /мян.төг/	бууруулсан зардал /мян.төг/	Хяналтаар ажиллах комиссын зардал /мян.төг/	Бүгд
1	Галшар	170	140		
2	Баянхутаг	130	110		
3	Баянмөнх	130	110		
4	Дархан	130	110		
5	Дэлгэрхаан	200	160		
6	Жаргалтхаан	140	120		
7	Цэнхэрмандал	130	110		
8	Өмнөдэлгэр	200	150		
9	Батширээт	150	120		
10	Биндэр	160	130		
11	Баян-Адрага	130	110		
12	Дадал	180	140		
13	Норовлин	150	120		
14	Батноров	170	130		
15	Баян-Овоо	150	120		
16	Мөрөн	150	120		
17	Хэрлэн	230	190		
18	Бор-Өндөр	120	110		
19	Бэрх	120	110		
20	Гурванбаян	130	100		
21	Статистикийн хэлтэс			1.090	
	Дүн	3.070	2.510	1.090	3.600

ТӨРИЙН САН
МЭРГЭЗ, АЖЛАХ | 382